



**Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчээр бүртгүүлэхэд  
шаардагдах материал**  
(Аж ахуйн нэгж)

1. Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчээр бүртгүүлэх тухай хүсэлтээ ХХААХҮЯ-ны Жижиг, дунд үйлдвэр, хоршооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт гэж хаяглан албан бичгээр ирүүлэх ба доорх зүйлсийг тусгасан байх. Үүнд:
  - Одоо эрхэлж буй үйл ажиллагааны чиглэл
  - Тодорхойлолтын зориулалт
  - Байгууллагын албан ёсны хаяг, утасны дугаар, цахим хаяг
2. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
3. Ажиллагчдыг нийгмийн даатгалд хамруулсан тухай тодорхойлолт. Дараах баримт бичгийн аль нэгийг хүчин төгөлдөрт тооцно. Үүнд:
  - Харъяа дүүрэг/сумын Нийгмийн даатгалын хэлтсийн тодорхойлолт (даатгуулагчийн тоог тусгах)
  - Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолт /цахимаар эсвэл ТҮЦ машинаас авсан тодорхойлолт/
4. Өмнөх жилийн аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлан /[www.e-tax.mn](http://www.e-tax.mn), маягт ТТ-02/
5. Өмнөх жилийн санхүүгийн баталгаажсан тайлан /[www.e-balance.mof.gov.mn/](http://www.e-balance.mof.gov.mn/)
6. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн лавлагаа /ТҮЦ машины лавлагаа эсвэл УБЕГ-аас авсан лавлагаа/
7. Тус компанид 20 болон түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшдэг өөр компани байдаг бол тэдгээр компаниудын улсын бүртгэлийн гэрчилгээ, нийгмийн даатгалын тодорхойлолт, өмнөх жилийн санхүүгийн болон татварын баталгаажсан тайлангийн хуулбарыг хавсаргах



Жижиг, дунд үйлдвэр эрхлэгч ИРГЭН-ээр бүртгүүлэхэд  
шаардлагатай материалын жагсаалт

1. Хүсэлт /маягтын дагуу бөглөх/
2. Иргэний үнэмлэхийн хуулбар /иргэний үнэмлэхийн хаяг дээрээ оршин суудаггүй бол шилжилт хөдөлгөөн хийснийг тэмдэглэсэн нарийн хуудсыг хамт хуулбарлах эсвэл ТҮЦ машины лавлагаа/
3. Контракт, хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчдыг нийгмийн даатгалд хамруулсан тухай нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт/НД-ын дэвтрийн хуулбар эсвэл ТҮЦ машины лавлагаа/;
4. Харъяа татварын байгууллагаар баталгаажуулсан сүүлийн жилийн татвар тодорхойлох хуудас буюу татварын цэнхэр дэвтэр түүний хуулбар

ИРГЭНД өмнө нь татвараас олгож байсан гэрчилгээг олгохгүй, аж ахуйн нэгжүүдтэй адил ТОДОРХОЙЛОЛТ олгохоор болсон. Учир нь зарим аймгуудад гэрчилгээ байхгүй, гэрчилгээ нь үнэт цаас учраас 5000 төгрөгийн хураамж авах ёстой зэрэг асуудлууд гараад байна.

